



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/768.

Ховд

「Бүлэг нэмж, тусгай зөвшөөрөл олгох тухай」

Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 30 дугаар зүйлийн 30.1.6, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Жаргалант сумын Бичигт багт байрлах 13 дугаар цэцэрлэг, Жаргалан багт байрлах Насан туршийн боловсрол төвийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 жилээр сунгасугай.

2. Жаргалант сумын Бугат багийн нутаг дэвсгэрт байрлах 15 дугаар цэцэрлэгт 1, Алтай сумын Тахилт багт байрлах цэцэрлэгт 1, Дарви сумын Булган багт байрлах цэцэрлэгт 3, Манхан сумын Төгрөг гол багт байрлах цэцэрлэгт 2, Мянгад сумын Баянхошуу багт байрлах цэцэрлэгт 2, Зэрэг сумын Хөндлөн багт байрлах цэцэрлэгт 1, Цэцэг сумын Хөшөөт багт байрлах салбар цэцэрлэгт 1 бүлгийг тус тус сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд нэмж ажиллуулсугай.

3. Цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар /М.Пүрэвхүү/-т даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны А/526, А/510 дугаар захирамжуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ